ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ, ТАРХАЛТЫН МЭДЭЭ

Хоёр долоо хоног тутмын мэдээ, №13 *2017.07.15*

НЭГ. Шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2017 оны 07-р сарын 01-ээс 07-р сарын 15-ны хүртэлх хугацаанд Номхон далайн баруун бүсийн 4 оронд хүний өвчлөлийн **шинэ тохиолдол** бүртгэгдээгүй байна.(Хүснэгт 1)

ХОЁР. 2003 оноос хойш бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл ба нас баралт:

2003 оноос 2017 оны 07-р сарын 15-ны хүртэлх хугацаанд дэлхийн 16 улсад шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусын 859 тохиолдол бүртгэгдсэнээс 453 (52.8%) нь нас барсан байна. 2003 оноос хойш Номхон далайн баруун бүсийн 4 оронд 238 тохиолдол бүртгэгдсэнээс 134 (56%) нь нас барсан байна. Камбожи улсад нас баралтын түвшин хамгийн өндөр (66%; 37/56) байна.

ГУРАВ. Шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2017 оны 07-р сарын 01-ээс 07-р сарын 15-ны хүртэлх хугацаанд шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусын хүний өвчлөлийн **шинэ тохиолдол** бүртгэгдээгүй байна.

2014 оны 5-р сараас хойш БНХАУ-д лабораторoор батлагдсан нийт 16 тохиолдлоос 6 (37.5%) нь нас барсан байна.

Хүснэгт 1. ДЭМБ-д мэдээлэгдсэн томуугийн А (H5N1) вирусын халдварын хүний өвчлөл, нас баралт, бодит тоогоор, 2003 – 2017.07.15

Улс	2003-2011		2012		2013		2014		2015		2016		2017		Нийт	
	Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н	Т	Н
Камбожи	18	16	3	3	26	14	9	4	0	0	0	0	0	0	**56**	**37**
Хятад	41	27	2	1	2	2	2	0	6	1	0	0	0	0	**53**	**31**
Лаос	2	2	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	**2**	**2**
Вьетнам	119	59	4	2	2	1	2	2	0	0	0	0	0	0	**127**	**64**
Нийт	180	104	9	6	30	16	13	6	6	1	0	0	0	0	**238**	**134**

Тэмдэглэгээ: (**Т**)-тохиолдол; (**Н**)-нас баралт

ДӨРӨВ. Шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусын хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:

2017 оны 07-р сарын 01-ээс 07-р сарын 15-ны хүртэлх хугацаанд шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусын хүний өвчлөлийн **шинэ тохиолдол** бүртгэгдээгүй байна.

2013 оноос хойш шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусын хүний өвчлөлийн нийт 1533 тохиолдол лабораторoор батлагдсан байна.

ТАВ. Шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусын шувууны өвчлөлийн мэдээлэл:

2017.07.01 - 07.15

Тив	Улс	Өртөмхий	Өвчтэй	Үхсэн	Устгасан	Нядалсан	Өртөмхий зүйл
Африк	Того	35000	3600	3448	152	0	Тахиа
Ази	Вьетнам	1135	500	300	835	0	Тэжээвэр шувуу /Зүйл тодорхойгүй/
Нийт		36135	4100	3748	987	0	-

Албан ёсны эх сурвалж:

- http://www.who.int/influenza/human_animal_interface/H5N1_cumulative_table_archives/en/index.html
- http://www.who.int/influenza/human_animal_interface/EN_GIP_20140727CumulativeNumber H5N1cases.pdf
- http://www.wpro.who.int/outbreaks_emergencies/H7N9/en/index.html
- http://www.who.int/influenza/human_animal_interface/influenza_h7n9/en/index.m
- http://www.wpro.who.int/emerging_diseases/aiweekly_465_09jan2015.pdf?ua=1
- http://empres-i.fao.org/eipws3g/#h=0

ЗӨСҮТ

ЭУББТСТ

ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧИН ХАРИУЦСАН БАГ